ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn
2026.02.25 № 1-6/149

танай____________-ны №______________-т

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ГАНТӨМӨР ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2025 онд биеийн тамир, спортын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт, хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн

442505142

удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Биеийн тамир, спортын улсын хорооны газрын даргаар батлуулж, хэрэгжилт 80.6 хувьтай үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.25 № 1-6/149

танай____________-ны №______________-т

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ГАНТӨМӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2025 онд биеийн тамир, спортын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт, хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн

442505142

удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Биеийн тамир, спортын улсын хорооны газрын даргаар батлуулж, хэрэгжилт 80.6 хувьтай үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ДГА-2026/113/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дорноговь аймаг<br>2026 он | Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,<br>Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий<br>Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр<br>Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn<br>Ахлах аудитор/Аудитор: Б.Алтанцэцэг<br>Утас: 8000-7121 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com<br>Аудитор Г.Шүрэнцэцэг<br>Утас: 8905-6740 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 11
   - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 11
   - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 11
   - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 11
   - 3.4 Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар ..... 12
   - 3.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 12
   - 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 12
   - 3.7 Нэгдсэн судалгааны үр дүн ..... 13
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 14
   - 4.1 Ерөнхий зүйл ..... 14
   - 4.2 Материаллаг байдал ..... 14
   - 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 14
   - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14
   - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
   - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 15
   - 5.1 Төлбөрийн акт .....
   - 5.2 Албан шаардлага ..... 15
   - 5.3 Зөвлөмж ..... 16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 17


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| КОД | БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ | ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **225,120,299.24** | **298,477,203.05** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 14,353,434.00 | 0.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 14,353,434.00 | 0.00 |
| **3121** | **Төгрөг** | 14,353,434.00 | 0.00 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 14,353,434.00 | 0.00 |
| **33** | **АВЛАГА** | 27,270,919.45 | 62,245,086.26 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,473,170.00 | 1,456,499.34 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 14,431,300.00 | 7,760,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 11,366,449.45 | 53,028,586.92 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 11,366,449.45 | 53,028,586.92 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 183,495,945.79 | 236,232,116.79 |
| **351** | **Түүхий эд материал** | 54,200.00 | 0.00 |
| 35130 | Эм боох материал | 54,200.00 | 0.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 183,441,745.79 | 236,232,116.79 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 806,200.00 | 1,026,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 122,113,442.69 | 175,283,713.69 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,212,100.00 | 2,212,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 600,000.00 | 0.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 57,710,003.10 | 57,710,003.10 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,476,143,809.64** | **9,624,499,864.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 9,476,143,809.64 | 9,624,499,864.11 |
| **392** | **Биет хөрөнгө** | 8,513,842,309.64 | 8,662,348,364.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,352,637,232.00 | 9,802,477,557.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,088,290,315.28) | (1,349,265,970.29) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 33,600,000.00 | 33,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (25,200,000.18) | (30,800,000.22) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 250,224,064.00 | 282,709,847.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (168,064,649.65) | (207,041,621.61) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 179,112,000.00 | 179,752,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (82,121,271.14) | (104,209,697.54) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 68,190,000.00 | 68,190,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (6,250,750.11) | (13,069,750.23) |
| 39217 | Ном | 6,000.00 | 6,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 962,301,500.00 | 962,151,500.00 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (462,500.00) | (612,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 961,264,000.00 | 961,264,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **9,701,264,108.88** | **9,922,977,067.16** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **989,449.66** | **1,641,294.18** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 989,449.66 | 1,641,294.18 |
| **413** | **Өглөг** | 989,449.66 | 1,641,294.18 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 276,249.66 | 0.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 928,094.18 |
| **4136** | **Бусад өглөг** | 713,200.00 | 713,200.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 713,200.00 | 713,200.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **9,700,274,659.22** | **9,921,335,772.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 9,700,274,659.22 | 9,921,335,772.98 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,399,092,204.56 | 1,399,092,204.56 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,399,092,204.56 | 1,399,092,204.56 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 7,929,533,972.61 | 8,150,595,086.37 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,321,821,604.22 | 7,929,533,972.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 607,712,368.39 | 221,061,113.76 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 371,648,482.05 | 371,648,482.05 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **9,701,264,108.88** | **9,922,977,067.16** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,401,729,504.52** | **3,602,566,460.52** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **865,513,898.10** | **565,041,446.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 865,513,898.10 | 565,041,446.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,471,300.00 | 88,112,671.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,471,300.00 | 88,112,671.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 799,932,595.00 | 462,948,108.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 53,110,003.10 | 13,980,667.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,536,215,606.42** | **3,037,525,014.52** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 857,754,317.06 | 1,059,605,596.66 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 762,107,167.06 | 1,051,979,267.66 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 95,647,150.00 | 7,626,329.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 563,111,589.36 | 579,877,317.86 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 563,111,589.36 | 579,877,317.86 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 1,115,349,700.00 | 1,398,042,100.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,115,349,700.00 | 1,398,042,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,794,017,136.13** | **3,381,505,346.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,794,017,136.13** | **3,381,505,346.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,517,078,575.35 | 2,965,161,642.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,334,285,367.78 | 1,617,678,313.47 |
| 210101 | Үндсэн цалин | 800,683,827.24 | 902,630,829.89 |
| 210102 | Нэмэгдэл | 415,108,134.51 | 543,227,351.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 64,048,000.00 | 126,859,832.95 |
| 210104 | Урамшуулал | 52,281,406.03 | 44,960,298.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 156,459,360.26 | 183,814,215.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 109,674,393.63 | 127,286,660.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,229,105.59 | 16,019,265.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,069,146.45 | 9,304,340.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,136,684.65 | 6,076,236.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,350,029.94 | 25,127,712.21 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 560,129,409.36 | 565,805,412.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,554,410.16 | 21,474,078.04 |
| 210302 | Түлш, халаалт | 521,019,168.00 | 518,317,730.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,555,831.20 | 26,013,604.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,143,566.90 | 17,883,981.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,642,100.00 | 2,664,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,272,712.00 | 1,286,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 480,022.40 | 799,974.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 491,000.00 | 458,985.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,257,732.50 | 12,673,722.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 54,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 54,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,900,980.00 | 14,781,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,900,980.00 | 14,781,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,446,600.00 | 1,738,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,446,600.00 | 1,738,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,652,516.00 | 2,199,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 387,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,000.00 | 53,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 44,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 479,600.00 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,104,166.00 | 1,273,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 413,060,775.05 | 561,206,720.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 98,455,900.00 | 226,596,667.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 314,604,875.05 | 334,610,053.53 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 276,938,560.78 | 416,343,703.82 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 20,045,838.00 | 11,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,857,950.00 | 11,400,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 256,892,722.78 | 404,823,703.82 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 143,108,603.82 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 231,842,788.59 | 261,715,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 120,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 120,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **607,712,368.39** | **221,061,113.76** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **607,712,368.39** | **221,061,113.76** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4417144353
ЕЮА0056 90

(төгрөгөөр)

| **КОД** | **ҮЗҮҮЛЭЛТ** | **ӨМНӨХ ОН** | **ТАЙЛАНТ ОН** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,542,642,733.42** | **3,161,470,831.52** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **121,572,146.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 92,700,671.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 92,700,671.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 92,700,671.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 14,283,864.00 | 28,871,475.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,542,642,733.42** | **3,039,898,685.52** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 864,181,444.06 | 1,061,979,267.66 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 762,107,167.06 | 1,051,979,267.66 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 102,074,277.00 | 10,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 563,111,589.36 | 579,877,317.86 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 563,111,589.36 | 579,877,317.86 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 1,115,349,700.00 | 1,398,042,100.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,115,349,700.00 | 1,398,042,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,545,844,733.42** | **3,155,806,265.52** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,545,844,733.42** | **3,155,806,265.52** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,269,157,922.64** | **2,697,800,424.23** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,349,929,729.78 | 1,646,549,788.47 |
| 210101 | Үндсэн цалин | 811,318,870.88 | 931,502,304.89 |
| 210102 | Нэмэгдэл | 415,041,995.98 | 543,227,351.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 69,903,700.00 | 126,859,832.95 |
| 210104 | Урамшуулал | 51,949,176.92 | 44,960,298.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 156,733,162.60 | 184,364,165.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 109,800,613.26 | 127,836,610.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,328,106.97 | 16,019,265.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,103,206.71 | 9,304,340.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,138,004.86 | 6,076,236.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,363,230.80 | 25,127,712.21 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 560,129,409.36 | 564,877,317.86 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,554,410.16 | 21,882,354.04 |
| 210302 | Түлш, халаалт | 518,488,234.00 | 519,413,349.82 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,086,765.20 | 23,581,614.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,559,089.40 | 26,505,365.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,656,500.00 | 1,808,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 535,022.40 | 791,174.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 491,000.00 | 765,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,565,055.00 | 23,140,191.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 49,005,680.00 | 42,927,920.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,513,100.00 | 16,770,820.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,472,030.00 | 26,157,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,759,900.00 | 1,738,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,759,900.00 | 1,738,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 32,741,552.00 | 2,199,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 387,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,000.00 | 53,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 44,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 479,600.00 | 440,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 1,104,166.00 | 1,273,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 105,299,399.50 | 228,638,267.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 105,299,399.50 | 228,638,267.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **276,686,810.78** | **458,005,841.29** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,794,088.00 | 11,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,606,200.00 | 11,400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 256,892,722.78 | 446,485,841.29 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 143,108,603.82 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 25,049,934.19 | 41,662,137.47 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 231,842,788.59 | 261,715,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 120,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 120,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-3,202,000.00** | **5,664,566.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **20,018,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **20,018,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 20,018,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 20,018,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **-20,018,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -3,202,000.00 | -14,353,434.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 3,271,570.00 | 14,353,434.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 14353434 | 0 |

4417144353
ЕЮА0056 9025707

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ | ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ | ХУРИМТЛАГДСАН ДҮН | ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,399,092,204.56 | 372,305,817.05 | 7,321,164,269.22 | 9,092,562,290.83 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 657,335.00 | 657,335.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,399,092,204.56** | **372,305,817.05** | **7,321,821,604.22** | **9,093,219,625.83** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | (657,335.00) | - | (657,335.00) |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 607,712,368.39 | 607,712,368.39 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,399,092,204.56** | **371,648,482.05** | **7,929,533,972.61** | **9,700,274,659.22** |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,399,092,204.56** | **371,648,482.05** | **7,929,533,972.61** | **9,700,274,659.22** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,399,092,204.56** | **371,648,482.05** | **7,929,533,972.61** | **9,700,274,659.22** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 221,061,113.76 | 221,061,113.76 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,399,092,204.56** | **371,648,482.05** | **8,150,595,086.37** | **9,921,335,772.98** |

4417144353
ЕЮА0056 9025707

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | **14,353,434.00** | **-** |
| **12** | **Татварын бус орлого** | **1,736,272,700.00** | **1,755,075,792.86** |
| **12000** | **Нийтлэг татварын бус орлого** | **595,058,500.00** | **589,877,317.86** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 585,058,500.00 | 579,877,317.86 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| **12200** | **Тусламжийн орлого** | **1,141,214,200.00** | **1,136,327,000.00** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,141,214,200.00 | 1,136,327,000.00 |
| **14** | **ОРЛОГО** | - | 28,871,475.00 |
| 140020 | Дансны орлого | - | 28,871,475.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,757,977,000.00** | **1,769,429,226.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,757,977,000.00** | **1,590,875,714.04** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,736,272,700.00** | **1,583,725,714.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **962,382,500.00** | **847,915,212.67** |
| 210101 | Үндсэн цалин | 538,517,700.00 | 518,850,912.24 |
| 210102 | Нэмэгдэл | 252,425,600.00 | 187,079,168.76 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 101,999,200.00 | 97,024,832.95 |
| 210104 | Урамшуулал | 69,440,000.00 | 44,960,298.72 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **119,922,100.00** | **90,617,174.51** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,580,200.00 | 62,556,801.22 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,618,700.00 | 8,014,231.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,827,400.00 | 4,424,985.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,769,600.00 | 2,800,983.69 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,126,200.00 | 12,820,172.51 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,051,300.00 | 6,135,142.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,876,400.00 | 1,428,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,988,700.00 | 791,174.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,196,200.00 | 765,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,990,000.00 | 3,149,968.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 570,058,500.00 | 564,877,317.86 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 24,839,600.00 | 21,474,078.04 |
| 210302 | Түлш, халаалт | 519,795,300.00 | 519,413,349.82 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,423,600.00 | 23,989,890.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,000,000.00 | 14,880,000.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 15,000,000.00 | 14,880,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,738,500.00 | 1,738,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,738,500.00 | 1,738,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж** | 2,506,500.00 | 2,199,100.00 |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | - | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 387,000.00 | 387,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо | 53,800.00 | 53,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,800.00 | 44,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 747,400.00 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,273,500.00 | 1,273,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 54,613,300.00 | 55,363,267.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 54,613,300.00 | 55,363,267.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21,704,300.00 | 7,150,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,375,300.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,329,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 7,150,000.00 |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | - | 178,553,512.82 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 178,553,512.82 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | **1,144,679,938.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,144,679,938.66** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,134,092,710.19** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **798,634,575.80** |
| 210101 | Үндсэн цалин | 412,651,392.65 |
| 210102 | Нэмэгдэл | 356,148,183.15 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 29,835,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **93,746,991.39** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,279,809.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,005,034.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,879,355.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,275,253.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,307,539.70 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **20,990,223.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 380,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,610,223.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **47,355,970.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 35,438,870.00 |
| 210602 | Тавилга | 640,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,277,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **173,364,950.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 173,364,950.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,587,228.47** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,250,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,250,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **6,337,228.47** |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 6,337,228.47 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | **1,144,679,938.66** |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **92,700,671.00** |
| **1200** | **Нийтлэг татварын бус орлого** | **92,700,671.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **92,700,671.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 92,700,671.00 |
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,051,979,267.66** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,051,979,267.66** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 1,051,979,267.66 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Биеийн тамир спортын газар нь "Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлж, бодлогын үр нөлөөг дээшлүүлж, олон талт, тэгш, хүртээмжтэй чанартай биеийн тамир, спортын үйлчилгээг хэрэгжүүлэн эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант онд Биеийн тамир, спортын тухай хуульд тухай хуульд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлүүдийг мөрдөж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
5. Хувь хүний орлогын албан татварын тухай
6. Төрийн хэмнэлтийн тухай
7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаа нь зөвхөн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдэж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газар 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Соёлын яамнаас 2025 оны А/163 дугаар тушаалаар батлан гаргасан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ашиглаж байна.

### 3.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газар 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 221,713.0 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна. Энэ нь үндсэн хөрөнгө, бараа материал, авлага дансы үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 1.* *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 14,353.4 | - | (14,353.4) |
| Авлага | 27,270.9 | 62,245.1 | 34,974.2 |
| Бараа материал | 183,495.9 | 236,232.1 | 52,736.2 |
| Үндсэн хөрөнгө | 9,476,143.8 | 9,624,499.9 | 148,356.1 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **9,701,264.1** | **9,922,977.1** | **221,713.0** |
| Богино хугацаат өр төлбөр | 989.4 | 1,641.3 | 651.8 |
| Засгийн газрын хувь оролцоо | 9,700,274.7 | 9,921,335.8 | 221,061.1 |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **9,701,264.1** | **9,922,977.1** | **221,713.0** |

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,671.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 572.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,136,327.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 579,877.3 мянган төгрөг,, урд оны үлдэгдлээс 28,871.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 28,871.5 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлж ажилласан байна.

*Хүснэгт 2.* *Төсвийн орлогын гүйцэтгэл*

*(мянган төгрөгөөр)*

| Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт, хувиар |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| Орлого бүрдүүлэлт | **1,736,272.7** | **1,755,075.8** | **18,803.1** | **101.1** |
| Улсын төсвөөс | 1,141,214.2 | 1,136,327.0 | (4,887.2) | 99.6 |
| Орон нутгийн төсвөөс | 585,058.5 | 579,877.3 | (5,181.2) | 99.1 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 10,000.0 | 10,000.0 | - | 100.0 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | 28,871.5 | 28,871.5 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар улсын төсвөөс 1,051,979.3 мянган төгрөгийн санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлогоос 92,700.7 мянган төгрөгийн орлого төвлөрсөнөөс 6,337.3 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг хийж, үлдсэн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төлөвлөсөн төсөл, хөтөлбөр байхгүй.

### 3.7 Нэгдсэн судалгааны үр дүн

**-Унаа хоолны хөнгөлөлтийн тариф:**

Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоол, Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Б/21 дүгээр тушаалаар 1 өдрийн хоолны зардал 20.0 мянган төгрөгөөр тогтоож тайлант онд 97,024.8 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

**- Гадаад томилолт, арга хэмжээ:**

Зардал гараагүй.

**- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал:**

Зардал гаргаагүй байна.

**- Программ хангамжийн бүртгэл, тайлагналттай холбоотой зардал:**

Хас эрин орчил компанийн санхүүгийн програамыг 2022 оноос ашиглаж байна. Тус программыг 1,500.0 мянган төгрөгөөр худалдан авч, тайлант онд 440.0 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна.

**- Сургалт, семинар, хурал зөвөлгөөнд зарцуулсан зардал:**

Зарцуулаагүй байна.

**- Бүтэц орон тооны цомхотгол:**

Төлөвлөгөөгөөр нийт 70 орон тоотой ажиллахаар баталснаас, гүйцэтгэлээр үндсэн 61 орон тоотой ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Толин этүгэн аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Алтанцэцэг, чанарын хяналтыг  менежер Д.Гэрэлхүү, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер У.Оюунтүлхүүр, Дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газар 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт  зардлаас 1.5 хувиар буюу 41,910.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, бичиг хэрэг, аж ахуйн хэрэглээний зардлаа хэмнэх арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуульд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, тогтмол мэдээлэх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд тусгайлан аудит хийгдээгүй болно.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн завсрын аудитаар акт, албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 1,105,674.4 | 1 | 1,105,674.4 | 100 |
| **Нийт дүн** | 1 | 1,105,674.4 | 1 | 1,105,674.4 | **100** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй.

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,331.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 1,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 2,331.6 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч ажилласан.

## 5.2 Албан шаардлага

*Илрүүлэлт1:*

Биеийн тамир спортын газрын даргын 2025 оны А/19 дугаар тушаалаар аймгийн явган алхалтын холбооны 1 тамирчны дэлхийн ноён оргил Эверестийн үндсэн отог Лобуче оргил, Кала паммер оргилуудад авирах замын зардлын дэмжлэгт 1,000.0 мянган төгрөгийг зардлын ангилал буруу зориулалт бусаар олгосон байна.

*Өгсөн албан шаардлага:*

Сангийн сайдын баталсан "Зардлын зарим ангиллыг шинэчлэн батлах тухай" 2025 оны 112 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах.

## 5.3 Зөвлөмж

*Илрүүлэлт1:*

Биеийн тамир спортын газрын даргын 2025 оны А/30 дугаар тушаалаар албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор " албан хаагчдын нэгдсэн сургалт, спортын арга хэмжээ"-г зохион байгуулж зардалд 2,000.0 мянган төгрөгийг зарцуулснаас хоолны зардалд 55 хүнд 1,100.0 мянган төгрөг, шагналд 900.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

*Өгсөн зөвлөмж:*

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах.

*Илрүүлэлт2:*

Даргын 2025 оны А/14 дугаар тушаалаар Монголын олимпын хороотой хамтран зохион байгуулах сургалтын зардалд 1,231.6 мянган төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэснээс шүтээн барилга 5 ширхэг 750.0 мянган төгрөг, Ханбаянзүрх хайрханы зураг 5 ширхэг 250.0 мянган төгрөг буюу бэлэг дурсгалд 1,000.0 мянган төгрөгийг, кофе, салфетка, жигнэмэг торт, ёотон, чокопай зэрэгт 231.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж үр ашиггүй зардал гаргасан.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийн хуулийг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Биеийн тамир спортын газрын даргын 2025 оны А/19 дугаар тушаалаар аймгийн явган алхалтын холбооны 1 тамирчны дэлхийн ноён оргил Эверестийн үндсэн отог Лобуче оргил, Кала паммер оргилуудад авирах замын зардлын дэмжлэгт 1,000.0 мянган төгрөгийг олгосон. | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | | | | |
| Биеийн тамир спортын газрын даргын 2025 оны А/30 дугаар тушаалаар албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор " албан хаагчдын нэгдсэн сургалт, спортын арга хэмжээ"-г зохион байгуулж зардалд 2,000.0 мянган төгрөгийг зарцуулснаас хоолны зардалд 55 хүнд 1,100.0 мянган төгрөг, шагналд 900.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан. | 1 | 1,100.0 | | | | | 1 | 1,100.0 | | |
| Даргын 2025 оны А/14 дугаар тушаалаар Монголын олимпын хороотой хамтран зохион байгуулах сургалтын зардалд 1,231.6 мянган төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэснээс шүтээн барилга 5 ширхэг 750.0 мянган төгрөг, Ханбаянзүрх хайрханы зураг 5 ширхэг 250.0 мянган төгрөг буюу бэлэг дурсгалд 1,000.0 мянган төгрөгийг, кофе, салфетка, жигнэмэг торт, ёотон, чокопай зэрэгт 231.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж үр ашиггүй зардал гаргасан. | 1 | 1,231.6 | | | | | 1 | 1,231.6 | | |
| Нийт | 3 | 3,331.6 | | | 1 | 1,000.0 | 2 | 2,331.6 | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Нийт** | | | | | | | | |